



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/396

Номгон

Замын чиглэл тогтоох тухай

Аймгийн Засаг даргын 2024 оны А/348 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг, Шинэжинст сумын Засаг даргын 2024 оны 168 дугаар албан бичиг, "Эрдэнэ Монгол" ХХК-ний 2024 оны 215/24 дүгээр албан бичгээр ирүүлсэн санал, хүсэлтийг харгалзан Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5, 12.1.8, 17 дугаар зүйлийн 17.1, 17.3, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. "Баянхонгор аймгийн төв – Шинэжинст сумын төв" чиглэлийн орон нутгийн чанартай шороон авто замын төгсгөлөөс эхлэн Баянхөндий төслийн хүн, хүнс, шатахуун болон барилгын түр ачаа тээврийн чиглэлийг нэгдүгээр, солбицлын цэгийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Тогтоосон чиглэлийн дагуу замыг тэмдэгжүүлэн, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, замын арчлалтыг тогтмол гүйцэтгэн хүн, мал амьтан, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, тоосжилтыг бууруулах арга хэмжээг зохион байгуулж, орчны бохирдол үүсгэхгүй тээвэрлэлт хийхийг "Эрдэнэ Монгол" ХХК (А.Билгүүн)-д үүрэг болгосугай.

3. Замын чиглэл тогтоосонтой холбогдуулан иргэд, олон нийтэд сурталчлан мэдээлэхийг Шинэжинст сумын Засаг дарга (Б.Бат-Эрдэнэ)-д, авто зам, хөдөлгөөний аюулгүй байдалд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Б.Мөнхбаяр), Авто зам (тээвэр)-ын хяналтын Улсын ахлах байцаагч (М.Магвансүрэн) нарт, байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Д.Содномсамдан)-д тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.


ДАРГА



Д.МӨНХСАЙХАН


824010985

Аймгийн Засаг даргын 2024 оны 07 дугаар
сарын 25-ны өдрийн 129 дугаар
захирамжийн нэгдүгээр хэвсрэлт




БАЯНХӨНДИЙ ТӨСЛИЙН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЗОРЧИХ ШОРООН ЗАМЫН ЧИГЛЭЛ

БАЯНХОНГОР АЙМГААС БАЯНХӨНДИЙ ТӨСЛИЙН
ТАЛБАЙРУУ ЗОРЧИХ ЗАМЫН МАРШРУТ



---oOo---

Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар
сарын 05 -ны өдрийн 0396 дугаар
захирамжийн хоёрдугаар хайсралт



**БАЯНХӨНДИЙ ТӨСЛИЙН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЗОРЧИХ
ШОРООН ЗАМЫН ЧИГЛЭЛИЙН СОЛБИЦОЛ**

№	Цэгийн нэр	Өргөрөг	Уртгаг
1	2	3	4
Эхлэл 1	Шинэжинст сум	44°33'52.10"	99°18'47.92"
2	Цагаан хаалга	44°25'11.76"	99°18'23.76"
3	Үзүүр худаг	44°10'41.91"	99°11'44.25"
4	Эргэлтийн цэг 1	44°07'36.65"	99°05'46.33"
5	Эргэлтийн цэг 2	44°07'36.65"	99°03'46.33"
6	Эргэлтийн цэг 3	44°06'5.04"	99°02'22.33"
7	Эргэлтийн цэг 4	44°06'4.61"	98°55'2.07"
8	Эргэлтийн цэг 5	44°01'6.34"	98°48'52.86"
Төгсгөл 9	Баянхөндий төсөл	43°54'6.77"	98°48'7.94"

---oOo---